

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**Даатгалын салбарын 2014 оны 2 дугаар
улирлын санхүү, даатгалын үйл ажиллагааны
нэгдсэн танилцуулга**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА	Д. БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Г. ХЭРЛЭН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМБА
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х. БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С. ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН БТХ-ИЙН ДАРГА	П. ЦЭРЭНДЭЖИД

БОЛОВСРУУЛСАН:

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э. ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	---------------

2014.08.15

1. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.1 Ерөнхий мэдээлэл

2014 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын компани 17, даатгалын төлөөлөгч 3399, даатгалын зуучлагч компани 24, даатгалын хохирол үнэлэгч компани 17, актуарч 15, нийт 3472 тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх эзэмшигчид даатгалын салбарт үйл ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт 1

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Үзүүлэлт	II.11	II.12	II.13	II.14
Даатгагч	17	18	17	17
Даатгалын компанийн төлөөлөгчийн газар			4	7
Даатгалын компанийн салбар	149	191	240	254
Даатгалын төлөөлөгч	1992	2180	3227	3399
Даатгалын зуучлагч	9	13	20	24
Даатгалын зуучлагч компанийн салбар			36	77
Даатгалын хохирол үнэлэгч	7	9	11	17
Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар				9
Актуарч	12	15	15	15
Дүн	2037	2235	3290	3472

Тайлант хугацаанд Хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 196 дүгээр тогтоолоор “Соёмбо Ай Би” ХХК-д, Хорооны 2014 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 197 дугаар тогтоолоор “Худалдаа хөгжлийн банк” ХХК-д, 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолоор “Ваясню

солюшн” ХХК-д тус тус даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.


Хорооны 2014 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор “Мастер үнэлгээ” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

1.2 Даатгагчийн хөрөнгө

2014 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 136.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 23.5 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн мөн үеийнхээс 3.0 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 28.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 1

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ



2014 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад эхний нэг компани 18.2 хувийг, эхний гурван компани 35.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	10805,3	7,90
2	Бодь даатгал ХХК	13203,6	9,66
3	Ган зам даатгал ХХК	3910,1	2,86
4	Гэр даатгал ХХК	3763,2	2,75
5	Мандал женерал даатгал ХХК	8820,1	6,45
6	МИГ даатгал ХХК	8701,2	6,36
7	Монгол даатгал ХХК	24931,4	18,23
8	Моннис даатгал ХХК	5090,5	3,72
9	Монре даатгал ХХК	4956,5	3,62
10	Мөнх даатгал ХХК	3512,1	2,57
11	Номин даатгал ХХК	7150,6	5,23
12	Нэйшнл лайф даатгал ХХК	5887,2	4,31
13	Практикал даатгал ХХК	8180,2	5,98
14	Соёмбо даатгал ХХК	7025,9	5,14
15	Тэнгэр даатгал ХХК	10863,3	7,94
16	УБ хотын даатгал ХХК	4509,7	3,30
17	Хаан даатгал ХХК	5427,8	3,97
Дүн		136738,7	100

Нийт хөрөнгийн бүтцийг эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн ангиллаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 3

Даатгалын компаниудын хөрөнгийн ангилал (сая төгрөг)

Үзүүлэлтүүд	13.06.30		14.06.30		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	96297,2	85,06	120204,1	87,91	23906,9	2,85
Эргэлтийн бус хөрөнгө	16918,3	14,94	16534,7	12,09	-383,6	-2,85
Нийт хөрөнгө	113215,5	100	136738,8	100	23523,3	0

Өмнөх оны мөн үеэс эргэлтийн хөрөнгө 23906.9 сая төгрөгөөр нэмэгдсэн буюу 3.55 пунктээр нэмэгдэж, харин эргэлтийн бус хөрөнгө 383.6 сая төгрөгөөр буурсан байдалтай байна.

Эргэлтийн хөрөнгийн бүтэц

Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2014 оны 2 дугаар улиралд 120.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 88.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 16.5 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 12.0 хувийг эзэлж байгаа бол 2013 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 96.3 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 85.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 16.9 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 15.0 хувийг эзэлж байсан байна.

Хүснэгт 4

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө (сая төгрөг)

Үзүүлэлтүүд	II.13		II.14		Өсөлт бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	57588,2	59,80	66706	55,49	9117,8	(4,31)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	22433,2	23,30	28000	23,29	5566,8	(0,01)
Дансны авлага	13810,5	14,34	21356,7	17,77	7546,2	3,43
Бусад эргэлтийн хөрөнгө	2465,3	2,56	4140,7	3,44	1675,4	0,88
Эргэлтийн хөрөнгийн дүн	96297,2	100	120203,4	100	23906,2	0

Эргэлтийн хөрөнгийн бүтцээр нь авч үзвэл 2014 оны 2 дугаар улиралд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 66.7 тэрбум төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 55.4 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 28.0 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 23.3 хувь, дансны авлага 21.3 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 17.8 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө 4.1 тэрбум буюу нийт эргэлтийн хөрөнгийн 3.4 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт эргэлтийн хөрөнгө 23.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь даатгалын компаниудийн

дүрмийн сангийн нэмэгдүүлэлт болон нэмэлт хөрөнгө оруулалт татсантай холбоотой.


Өмнөх оны мөн үеийнхээс мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 9.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч, нийт эргэлтийн хөрөнгөнд эзлэх хувийн жин 4.3 пунктээр буурч, хураамжийн авлага, бусад эргэлтийн хөрөнгө тодорхой пунктээр нэмэгдсэн байна.

1.3 Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 4 жилийн 2 дугаар улирлын байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна.

Дүрслэл 2

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч (хувиар)



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2011 оны 2 дугаар улиралд 47.0 хувийг эзэлж байсан бол 2012 оны 2 дугаар улиралд 47.1 хувь, 2013 оны 2 дугаар улиралд 47.0 хувь, 2014 оны мөн үед 47.3 хувь болсон нь актуар тооцооллоор нөөцийн санг нэмэгдүүлж ажиллаж эхэлсэнтэй холбоотой байна.

Тайлант онд нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх эзэмшигчийн өмчийн хувийн жин 6.4 пунктээр буурсан бол өр төлбөрийн хувийн жин 1.8 пунктээр, нөөцийн сангийн хувийн жин 0.3 пунктээр өмнөх оны мөн үеийнхээс тус тус өссөн байна.

1.4 Даатгалын хураамжийн орлого

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2014 оны 2 дугаар улирлын байдлаар 57.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.3 дахин өссөн байна.

Тайлант онд ердийн даатгалын компаниуд 56.4 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 0.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна. Ердийн даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 14.5 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин, урт хугацааны даатгалын орлого 0.2 тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 137.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын орлого нийт даатгалын хураамжийн орлогын 41.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5

Даатгалын хураамжийн орлого, бүтээгдэхүүнээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	13.06.30	14.06.30	Өөрчлөлт /хувиар/
		Даатгалын нийт хураамжийн орлого		
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3708,1	4774	1,29
2	Хөрөнгийн даатгал	10054,2	15065,2	1,50
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	8654,8	10220,9	1,18
4	Ачааны даатгал	911,8	1224,8	1,34
5	Барилга угсралтын даатгал	524,4	828,5	1,58
6	Мал амьтдын даатгал		190,2	-
7	Агаарын хөлгийн даатгал	3777,9	4093,6	1,08

8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	3229,5	2028,3	0,63
9	Хариуцлагын даатгал	4272,7	2904	0,68
10	Санхүүгийн даатгал	1163,3	1280,7	1,10
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	4844	10412,2	2,15
12	Зээлийн даатгал	708,5	1322,7	1,87
13	Итгэлцлийн даатгал		54,3	-
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой Хариуцлагын даатгал	83,3	1965,2	23,59
15	Хугацаат амьдралын даатгал	206,6	147,6	0,71
16	Хуримтлалын даатгал	60,9	53,4	0,88
17	Тэтгэврийн даатгал	26,2	30,8	1,18
18	Эрүүл мэндийн даатгал	190,2	473,5	2,49
	Дүн	42416,4	57069,9	43,25

Тайлант оны мөн үеийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийн үзүүлэлттэй харьцуулахад дээрх байдалтай харагдаж байна. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.29 дахин, хөрөнгийн даатгал 1.5 дахин, авто тээврийн хэрэгслийн даатгал 1.18 дахин, ачааны даатгал 1.34 дахин, барилга угсралтын даатгал 1.58 дахин, агаарын хөлгийн даатгал 1.08 дахин, санхүүгийн даатгал 1.10 дахин, зээлийн даатгал 1.86 дахин, тэтгэврийн даатгал 1.18 дахин, хувиар, эрүүл мэндийн даатгал 2.5 дахин тус тус нэмэгдэж, хариуцлагын даатгал 32.0 хувиар, хугацаат амьдралын даатгал 29.0 хувиар, хуримтлалтын даатгал 12.0 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6

Даатгалын компаниудын нийт орлогын хэмжээ (сая төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт орлого хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	6213,6	10,89
2	Бодь даатгал ХХК	9331,1	16,35
3	Ган зам даатгал ХХК	78,5	0,14
4	Гэр даатгал ХХК	152,2	0,27

5	Мандал генерал даатгал ХХК	3526,1	6,18
6	МИГ даатгал ХХК	4040,6	7,08
7	Монгол даатгал ХХК	15244,1	26,71
8	Моннис даатгал ХХК	1106,1	1,94
9	Монре даатгал ХХК	1705,2	2,99
10	Мөнх даатгал ХХК	343,3	0,60
11	Номин даатгал ХХК	2604,7	4,56
12	Нэйшнл лайф даатгал ХХК	705,3	1,24
13	Практикал даатгал ХХК	2472,3	4,33
14	Соёмбо даатгал ХХК	2726,3	4,78
15	Тэнгэр даатгал ХХК	4570,2	8,01
16	УБ хотын даатгал ХХК	618,9	1,08
17	Хаан даатгал ХХК	1631,4	2,86
	Дүн	57 069,90	100

2014 оны 2 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК 26.7 хувийг бүрдүүлсэн бол, нийт хураамжийн орлогын 53.95 хувийг эхний 3 компани бүрдүүлсэн байна.

1.5 Даатгалын нөхөн төлбөр

2014 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 15.6 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 40.2 хувийг эзэлж байна. Тайлант хугацааны даатгалын нөхөн төлбөрийг авч үзэхэд өмнөх оны мөн үеийнхээс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.5 дахин, агаарын хөлгийн даатгал 17.4 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.2 дахин, хариуцлагын даатгал 1.8 дахин, санхүүгийн даатгал 2.0 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 1.7 дахин, хугацаат амьдралын даатгал 1.3 дахин, эрүүл мэндийн даатгал 5.0 дахин тус тус өсч, бусад хэлбэрийн даатгал буурсан байна.

Хүснэгт 7

Даатгалын компаниудын нөхөн төлбөр хэлбэрээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	13.06.30	14.06.30	Өөрчл
---	------------------	----------	----------	-------

№	Даатгалын нийт нөхөн төлбөр	Даатгалын нийт нөхөн төлбөр		өлт /хувиар/
		Төлбөр	Хувь	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	974,5	1 462,60	1,50
2	Хөрөнгийн даатгал	1299	778,90	0,60
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	3353,6	4 258,10	1,27
4	Ачааны даатгал	126,3	118,6	0,94
5	Барилга угсралтын даатгал	25,3	60,2	2,38
6	Мал амьтдын даатгал			0,00
7	Агаарын хөлгийн даатгал	5,4	94,1	17,43
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1121,7	4,20	0,37
9	Хариуцлагын даатгал	160,2	287	1,79
10	Санхүүгийн даатгал	253,8	492,9	1,94
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	3650,7	6 080,30	1,67
12	Зээлийн даатгал	689,4	1665	2,4
13	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		1,8	
14	Хугацаат амьдралын даатгал	24	27	1,13
15	Хуримтлалын даатгал	36,8	26,8	0,73
16	Тэтгэврийн даатгал	2,6	10,9	4,19
17	Эрүүл мэндийн даатгал	57,9	196,4	5,0
Дүн		11 781,20	15 564,80	40,56

Тайлант онд барилга угсралтын даатгал, мал амьтдын даатгалын хэлбэрээр нөхөн төлбөр олгогдоогүй байна.

Хүснэгт 8

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн хэмжээ (сая төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт нөхөн төлбөр хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1496,7	9,62
2	Бодь даатгал ХХК	1679,4	10,79
3	Ган зам даатгал ХХК	22,9	0,15
4	Гэр даатгал ХХК	47,6	0,31
5	Мандал женерал даатгал ХХК	616,4	3,96

6	МИГ даатгал ХХК	1309,4	8,41
7	Монгол даатгал ХХК	4737,9	30,44
8	Моннис даатгал ХХК	18	0,12
9	Монре даатгал ХХК	506,1	3,25
10	Мөнх даатгал ХХК	99	0,64
11	Номин даатгал ХХК	1194,6	7,67
12	Нэйшнл лайф даатгал ХХК	261	1,68
13	Практикал даатгал ХХК	1316,4	8,46
14	Соёмбо даатгал ХХК	867,3	5,57
15	Тэнгэр даатгал ХХК	1192,3	7,66
16	УБ хотын даатгал ХХК	18,7	0,12
17	Хаан даатгал ХХК	181,3	1,16
Дүн		15565,0	100,00


Тайлант онд нийт даатгалын нөхөн төлбөрийн 30.44 хувийг нэг компани дангаараа эзэлсэн бөгөөд эхний 3 компани 51.0 хувийг эзэлсэн байна.

1.6 Даатгалын хохирлын харьцаа

2014 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын хохирлын харьцаа салбарын дүнгээр 45.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеийнхээс 2.7 пунктээр нэмэгдсэн буюу сүүлийн дөрвөн жилийн мөн үеийнхээс хамгийн их түвшинд байна.

Дүрслэл 3

Даатгалын хохирлын харьцаа



Даатгалын компаниудын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай харагдаж байна.

Хүснэгт 9

Даатгалын компаниудын хохирлын харьцаа (хувиар)

№	Даатгалын компаниуд	13.06.30	14.06.30	Өсөлт бууралт
1	Ард даатгал ХХК	33,40	66,00	32,60
2	Бодь даатгал ХХК	34,10	37,00	2,90
3	Ган зам даатгал ХХК	9,10	9,00	- 0,10
4	Гэр даатгал ХХК	32,30	23,00	- 9,30
5	Мандал генерал даатгал ХХК	31,20	37,00	5,80
6	МИГ даатгал ХХК	48,80	51,00	2,20
7	Монгол даатгал ХХК	53,00	50,00	- 3,00
8	Моннис даатгал ХХК	6,40	9,00	2,60
9	Монре даатгал ХХК	50,30	50,00	- 0,30
10	Мөнх даатгал ХХК	27,90	28,00	0,10
11	Номин даатгал ХХК	50,60	57,00	6,40
12	Нэйшнл лайф даатгал ХХК	26,70	37,00	10,30
13	Практикал даатгал ХХК	44,30	60,00	15,70
14	Соёмбо даатгал ХХК	53,00	36,00	- 17,00
15	Тэнгэр даатгал ХХК	36,90	42,00	5,10
16	УБ хотын даатгал ХХК	8,30	4,00	- 4,30
17	Хаан даатгал ХХК	21,30	16,00	- 5,30
Нийт хохирлын харьцаа		42,30	46,00	

Даатгалын компаниудын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 компанийн үзүүлэлт өсч, 7 компанийн үзүүлэлт буурсан байна. Хамгийн өндөр хохирлын харьцаатай буюу “Ард даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК-иуд тус тус 50-70 хувийн үзүүлэлттэй байна.

“Моннис даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-иудын хохирлын харьцаа 10.0 хувь хүрэхгүй байна.

1.7 Даатгагчийн ашигт ажиллагаа

2014 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын компаниуд салбарын хэмжээнд 1.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Нийт ердийн даатгалын 16 компани, урт хугацааны даатгалын 1 компанийн тайлант оны 2 дугаар улиралд дараах байдалтай байна.

Хүснэгт 10

Даатгалын компаниудын тайлант үеийн ашиг алдагдал (сая төгрөг)


№	Даатгалын компаниуд	13.06.30	14.06.30	Өсөлт бууралт
1	Ард даатгал ХХК	1853	334,4	0,18
2	Бодь даатгал ХХК	98,3	47,9	0,49
3	Ган зам даатгал ХХК	254,7	309,7	1,22
4	Гэр даатгал ХХК	50,1	121,9	2,43
5	Мандал генерал даатгал ХХК	103,7	-288,4	- 2,78
6	МИГ даатгал ХХК	94,7	137,4	1,45
7	Монгол даатгал ХХК	637,3	-13,8	0,02
8	Моннис даатгал ХХК	185,1	115,7	0,63
9	Монре даатгал ХХК	41,3	23,3	0,56
10	Мөнх даатгал ХХК	11	2,2	0,20
11	Номин даатгал ХХК	42,3	-74,9	- 1,77
12	Нэйшнл лайф даатгал ХХК	-41,9	14,4	0,34
13	Практикал даатгал ХХК	143,6	52	0,36
14	Соёмбо даатгал ХХК	-89,6	-34,3	0,38
15	Тэнгэр даатгал ХХК	449,3	464,8	1,03
16	УБ хотын даатгал ХХК	74,2	-8,7	0,12
17	Хаан даатгал ХХК	-413	127,8	0,31

Дүн	3494,1	1 331,40
-----	--------	----------

Тайлант оны үзүүлэлтийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ган зам даатгал” ХХК 1.2 дахин, “Гэр даатгал” ХХК 2.43 дахин, “Мандал женерал даатгал” ХХК 2.78 дахин, “Миг даатгал” ХХК 1.45 дахин, “Номин даатгал” ХХК 1.77 дахин, “Тэнгэр даатгал” ХХК 1.03 дахин тус тус цэвэр ашиг нэмэгдсэн бөгөөд бусад даатгалын компаниудын хувьд буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 4

Даатгагчийн хуримтлагдсан ашиг алдагдал (сая төгрөг)




1.8 Даатгалын нөөц сан

2014 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын нөөцийн сангийн үзүүлэлт дараах байдалтай байна.

Дүрслэл 5

Даатгалын нөөц сан /гэрбум төгрөгөөр/




Даатгалын нөөцийн сан 2011 оны мөн үеэс хойш 1.9 дахин буюу 30.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байдалтай байна.

1.9 Давхар даатгал

2014 оны 2 дугаар улирлын байдлаар 17.2 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг гадаадын давхар даатгалын компанид шилжүүлсэн байна.

Дүрслэл 6

Давхар даатгалын хураамж (сая төгрөгөөр)



Давхар даатгалын хураамжийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 1.7 дахин нэмэгдсэн байна. Давхар даатгалын хураамж сүүлийн дөрвөн жилийн байдлаар харахад нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 11

Давхар даатгалын хураамж (сая төгрөг)

№	Компанийн нэр	П.13	П.14	Өөрчлөлт хувиар
		тоо	тоо	
1	Ард даатгал ХХК	661,9	2328,1	3,52
2	Бодь даатгал ХХК	1746,1	4563,4	2,61
3	Тэнгэр даатгал ХХК	747,2	1303,7	1,74
4	Практикал даатгал ХХК	87,8	59	0,67
5	Миг даатгал ХХК	1117,2	449,4	0,40
6	Монгол даатгал ХХК	4653,6	6057,8	1,30

7	Номин даатгал ХХК	35,2	151,5	4,30
8	Нэйшнл лайф даатгал ХХК	29,6	5,4	0,18
9	Мандал женерал даатгал ХХК	560,4	985,3	1,76
10	Соёмбо даатгал ХХК	300,6	51,4	0,17
11	Моннис даатгал ХХК	1041,8	997,4	0,96
12	Хаан даатгал ХХК	0	129,2	-
13	Монре даатгал ХХК	54,7	111,3	1,4
Дүн		11036,1	17192,9	1,7

“Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК “Тэнгэр даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК-иудын давхар даатгалын хураамж өмнөх оны мөн үеийнхээс өсч, бусад даатгагчийн хувьд буурсан байна.

2. ЕРДИЙН ДААТГАЛ

2.1 Ердийн даатгал


Ердийн даатгалын компаниуд 2014 оны 2 дугаар улирлын байдлаар 16 даатгагч, 254 даатгалын салбар Улаанбаатар хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

2.2 Ердийн даатгалын нийт хөрөнгө

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 130.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 22.4 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл 7

Ердийн даатгалын нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)



Сүүлийн жилүүдэд нийт хөрөнгийн хэмжээ тогтмол нэмэгдсэн нь даатгалын салбарын хөрөнгө оруулалт, хураамжийн орлого зэрэг санхүүгийн үзүүлэлт өсч байгаатай холбоотой.

2.3 Ердийн даатгалын өр төлбөр ба эзэмшигчийн өмч

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 12

Эзэмшигчдийн өмчийн үзүүлэлт (сая төгрөг)

Үзүүлэлтүүд	II.13		II.14		Өсөлт бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хувь нийлүүлсэн хөрөнгө	46826,5	88,06	50590,2	82,54	3763,7	(5,52)
Хуримтлагдсан ашиг, алдагдал	6348,8	11,94	5964	9,73	-384,8	(2,21)
Бусад өмчийн хэсэг			4736,3	7,73	4736,3	7,73
Эзэмшигчийн өмчийн дүн	53175,3	100	61290,5	100	8115,2	

Тайлант оны 2 дугаар улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувь нийлүүлсэн хөрөнгө 3.7 тэрбум төгрөгөөр, бусад өмчийн хэсэг 4.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, хуримтлагдсан ашиг 0.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2.3 Ердийн даатгалын хураамжийн орлого

Тайлант оны 2 дугаар улиралд ердийн даатгалын компанийн хураамжийн орлого 56.4 тэрбум төгрөг, үүнээс давхар даатгалын хураамжид 17.2 тэрбум төгрөг, буцаасан даатгалд 1.0 тэрбум төгрөг төвлөрүүлж 38.1 тэрбум төгрөгийн цэвэр хураамжтай ажилласан байна. Даатгалын компаниудын хураамжийн орлогыг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 6 -д үзүүлсэн болно.

2.4 Ердийн даатгалын нөхөн төлбөр

Тайлант оны 2 дугаар улиралд ердийн даатгалын компанийн нийт нөхөн төлбөр 15.3 тэрбум төгрөг, үүнээс орлогод тооцсон хураамжаас олгосон нөхөн төлбөр 7.5 тэрбум төгрөг, нөөц сангаас олгосон нөхөн төлбөр 7.8 тэрбум төгрөг тус тус байна. Давхар даатгагчаас 1.0 тэрбум төгрөгийг нөхөн төлбөрт төлсөн байна. Мөн даатгалын нөхөн төлбөрийг 16361 хувь хүн, 8884 хуулийн этгээдэд тус тус олгосон байна. Даатгалын компаниудын нөхөн төлбөрийг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 8 -д үзүүлсэн болно.

2.4 Ердийн даатгалын хохирлын харьцаа, ашигт ажиллагаа

Тайлант оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа хохирлын харьцааг Хүснэгт 9-д харуулсан болно.

“Ард даатгал” ХХК нь хамгийн өндөр буюу 66.0 хувийн харьцаатай байна.

Ердийн даатгалын компаниуд тайлант оны 2 дугаар улиралд 1317.0 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан байна. “Мандал генерал даатгал” ХХК 288.4 сая төгрөг, “Монгол даатгал” ХХК 13.8 сая төгрөг, “Номин даатгал” ХХК 74.9 сая төгрөг, “Соёмбо даатгал” ХХК 34.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаар салбарын хэмжээний ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

Компаниудын ашиг алдагдлын дэлгэрэнгүйг Хүснэгт-10 д дэлгэрэнгүй харуулсан болно.

2.5 Ердийн даатгалын нөөц сан, давхар даатгал

Тайлант оны 2 дугаар улиралд нөөцийн сангийн үзүүлэлтийг сайн дурын даатгал, албан журмын даатгалын үзүүлэлтээр ангилж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 13

Ердийн даатгалын нөөц сан (тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	2014-02
Сайн дурын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	26.6
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	7.2
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	0.3
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	17.5
Албан журмын даатгал	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан	11.3
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	1.7
	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	0.1
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	1.5
Нийт нөөцийн сан		66.2

Компаниудын Орлогод тооцоогүй хураамжийн нөөц 57.2 хувийг, учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан 13.4 хувийг, нэхэмжилсэн хохирлын нөөцийн сан 0.6 хувийг, учирч болзошгүй хохирлын нөөц сан 28.7 хувийг тус тус эзэлсэн байна.

Ердийн даатгалын давхар даатгалын хураамжийн орлого тайлант оны 2 дугаар улиралд 17.2 тэрбум төгрөг байна. Хүснэгт 11-д харуулсан болно.


3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

3.1 Урт хугацааны даатгалын хөрөнгө, эзэмшигчийн өмч

Даатгалын салбарт “Нэйшнл лайф даатгал” ХХК нь 2008 оноос хойш урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Тус компанийн хөрөнгийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж ирсэн.

Дүрслэл 8

Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)




Тус компанийн нийт хөрөнгө 2011 оны мөн үеэс хойш 2.8 дахин нэмэгдсэн байна.

3.2 Урт хугацааны даатгалын хураамжийн орлого, давхар даатгал

Дүрслэл 9


Урт хугацааны даатгалын компанийн нийт хураамжийн орлогын хэмжээ (сая төгрөгөөр)



Тайлант оны 2 дугаар улиралд хураамжийн орлого 705.5 сая төгрөг болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.5 дахин, 2011 оны мөн үеэс 4.9 дахин нэмэгдсэн байна.

Дүрслэл 10

Давхар даатгал (сая төгрөг)



Давхар даатгалын хураамжид тайлант оны 2 дугаар улиралд 5.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 24.2 сая төгрөгөөр, 2011 оны мөн үетэй харьцуулахад 35.2 сая төгрөгөөр буюу 7.5 дахин буурсан байна.

3.2 Даатгалын компанийн ашигт ажиллагаа, нөөц сан


Урт хугацааны даатгагчийн ашигт ажиллагаа нөөцийн санг сүүлийн дөрвөн жилийн байдлаар харуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл 11


Урт хугацааны даатгалын компанийн ашигт ажиллагаа (сая төгрөг)

Дүрслэл 12

Урт хугацааны даатгалын компанийн нөөц сан (сая төгрөг)



Даатгагчийн нийт орлогын хэмжээ жил бүр нэмэгдсэнтэй холбоотой нөөцийн сангийн үзүүлэлт ч нэмэгдэх хандлагатай болсон байна. 2011 оны мөн үеэс хойш 8.0 хувиар нэмэгдсэн байна.



Тайлант үеийн 2 дугаар улиралд 14.4 сая төгрөгийн цэвэр ашигтай буюу анх удаа ашигтай ажилласан байна.

Даатгагчийн нөөцийн сангийн үзүүлэлтийг харуулбал:

4. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 16 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын /цаашид “жолоочийн даатгал” гэх/ үйл ажиллагаа эрхэлж байна.

Хураамж: 2014 оны 2 дугаар улирлын байдлаар жолоочийн даатгалын 259909 гэрээнээс нийт 10412.2 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч, 2013 оны мөн үеэс 5568.2 сая төгрөгөөр буюу 2.15 дахин өссөн байна.

2012-2014 оны 2 дугаар улирлын байдлаарх жолоочийн даатгалын хураамжийн орлого, нийт даатгалын хураамжтай харьцуулсан үзүүлэлтийг доорх графикаар харуулж байна.

Дүрслэл 13

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын орлого (хувиар)




Нөхөн төлбөр: 2014 оны 2 дугаар улирлын байдлаар 11776 жолоочийн даатгалын тохиолдолд нийт 6080.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон нь 2013 оны мөн үеэс 2429.6 сая төгрөгөөр буюу 1.67 дахин өссөн байна. 2012-2014 оны 2 дугаар улирлын байдлаарх жолоочийн даатгалын нөхөн төлбөр

болон даатгалын нийт нөхөн төлбөрийн үзүүлэлтийг доорх графикаар харуулж байна.

Дүрслэл 14

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр (хувиар)



Дүрслэл 15

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд ногдох даатгалын тохиолдлын тоо



2014 оны 2 дугаар улиралд даатгалын гэрээний тоо өмнөх оны мөн үеийнхээс 140207-оор даатгалын тохиолдлын тоо 4789-өөр тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын 100 гэрээ тутамд ногдох даатгалын тохиолдлын тоо 4.5 байна.

5. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

Даатгалын зуучлагч

Тайлант оны 2 дугаар улиралд нийт 24 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна.

Хүснэгт 14

Компаниудын зуучлалын хураамжийн орлого (сая төгрөг)

№	Компанийн нэр	13.06.30	14.06.30	Өөрчлөлт хувиар
1	“Асимон брокерс” ХХК	40,9	25,2	0,62
2	“Аме” ХХК	10,1	42,9	4,25
3	“Ачит ундарга” ХХК	24,8	8,9	0,36
4	“Лояалти солюшн” ХХК	16,5	125	7,58
5	“Эм жи ай би” ХХК	0		-
6	“Ренессанс групп” ХХК	26,4	15,4	0,58
8	“Пийс оф лайф” ХХК			-
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК		0	-
10	“Юу ай би” ХХК	13,5	12,8	-
11	“Гэрэлт буян ундрах” ХХК	3,5	67,4	19,26
12	“Нэйшнл эженси” ХХК	14,3	16,4	1,15
13	“Изи инвестмент” ХХК			-
14	“Си эн эн икс” ХХК	51,6	83,3	1,61
15	“Хаан банк” ХХК	1,1	189,6	172,36
16	“Хас банк” ХХК		22,6	-
17	“Эрсдлийн шийдэл” ХХК		519,3	-
18	Төрийн банк ХХК		62,8	-
19	Эй эс ай би ХХК			-
20	Хүннү сэйл ХХК		2,8	-
21	Капитал банк ХХК			-
22	Сүрэг хараацай ХХК		45,3	-
23	Худалдаа хөгжлийн банк			-

24	Ваяснью солюшн ХХК			-
	Дүн	202,7	1239,7	6,12

Тэмдэглэл: -үйл ажиллагаа эрхлээгүйг илэрхийлнэ.

Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 1239.7 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 6.1 дахин өссөн байна. Даатгалын зуучлалын хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Аме” ХХК 4.25 дахин, “Лояалти солюшн” ХХК 7.58 дахин, “Гэрэлт буян ундрах” ХХК 19.26 дахин, “Нэйшнл эженси” ХХК 1.15 дахин, “Си эн эн икс” ХХК 1.61 дахин тус тус нэмэгдэж “Асимон брокерс” ХХК 38.0 хувиар, “Ачит ундарга” ХХК 64.0 хувиар, “Ренессанс групп” ХХК 42.0 хувиар тус тус буурсан байна.

Нийт хураамжийн орлогын 41.9 хувийг “Эрсдлийн шийдэл” ХХК нь дангаараа бүрдүүлсэн байна. “Капитал банк” ХХК, “Сүрэг хараацай” ХХК, “Худалдаа хөгжлийн банк” ХХК, “Ваяснью солюшн” ХХК-иуд нь шинээр тусгай зөвшөөрөл авсан тул даатгалын зуучлалын орлого төвлөрүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 290.0 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 15

Компаниудын хохирол үнэлгээний орлого (сая төгрөг)

д/д	Компанийн нэр	13.06.30	14.06.30	Өөрчлөлт
1	“Бест эстимэйт” ХХК	16,1	11,9	0,72
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	49	46,4	0,95

Даатгалын салбарын тайлан СЗХ -2014/2

3	“Файн эстимэйт” ХХК	0	3,9	-
4	“Итгэлт эстимэйт” ХХК	22,3	25,3	1.14
5	“Мега марз” ХХК	5,9	5,8	0.98
6	“Вендо” ХХК	5,7	55	9,65
7	“Жи ай си си” ХХК	16,8	8,8	0,52
8	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0,3	0,5	1,67
9	Арвижих эстимэйт ХХК	9,5	18,9	1,99
10	Юу энд Эн		0	-
11	Тэгш сонголт эстимэйт		0,9	-
12	Ашид билгүүн ХХК	8,2	102,3	12.5
13	Арга билэг ХХК		0,7	
14	Фэйр валюшн ХХК		3,9	
15	Хос стандарт ХХК		2,9	

16	Сэлэнгэ эстимэйт ХХК		2	-
17	Мастер үнэлгээ ХХК		0,8	-
Дүн		134,3	290	-

2014 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын хохирол үнэлгээний орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Вендо” ХХК, 9.65 дахин, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК 1.67 дахин, “Арвижих эстимэйт” ХХК 1.99 дахин, “Ашид билгүүн” ХХК 12.5 дахин тус тус нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд “Юу энд эн” ХХК нь үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ

Даатгалын салбарын хэмжээнд 2014 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид 5.0 хувиар нэмэгдсэн байна. Даатгалын төлөөлөгч нийт тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчийн 97.8 хувийг эзэлж байна.

Нийт хөрөнгийн хэмжээ тайлант оны 2 дугаар улиралд 136.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн байна.

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчийн өмчид нөөцийн сангийн эзлэх хувь хэмжээ 47.3 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр нэмэгдсэн нь даатгалын актуарын үйл ажиллагаа сайжирсантай холбоотой юм.

Тайлант улиралд жолоочийн хариуцлагын даатгалын хураамж 18.4 хувийг эзэлж байгаа ч нөхөн төлбөр нь нийт нөхөн төлбөрийн 39.7 хувийг эзэлж байгаа нь

хохирлын харьцааг нэмэгдүүлэх үндэс болж байна. Даатгагчийн хохирлын харьцаа 45.0 хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2.7 пунктээр нэмэгдсэн.

Тайлант оны 2 дугаар улирлын байдлаарх урт хугацааны даатгалын үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөрөнгийн хэмжээ 1.2 дахин, нөөц сан 1.5 дахин нэмэгдэж, мөн тайлант үеийн ашиг 14.4 сая төгрөг буюу ашигтай ажиллаж эхэлсэн.

Даатгалын мэргэжлийн оролцогчдын зуучлалын үйл ажиллагааны орлого 6.1 дахин, хохирол үнэлгээний орлого 2.1 дахин тус тус нэмэгдсэн. Арилжааны 5 банк даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсантай холбоотой даатгалын зуучлагчийн орлого хурдацтай өсч байна.